



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

**Сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай**

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.1.8</sup>, 5<sup>1.1.11</sup>, 11.10 дахь заалт, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/46 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт”, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны 38 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Булган аймгийн Хутаг-Өндөр, Өвөрхангай аймгийн Богд, Сүхбаатар аймгийн Онгон, Эрдэнэцагаан, Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтэций сумдын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-ыг 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зарласугай.
2. “Сонгон шалгаруулалтын баримт бичиг”-ийг тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний ажлын хэсэг байгуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

М.БАТТУЛГА

Ч.ЗОЛБАЯР

Б.МЯГМАРНАРАН

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР